



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 122

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах  
тухай

Эрүүл мэндийн хуулийн 8 дугаар зүйлийн 1.1, 8.1.4, 8.1.11, 8.1.13, Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн 2 дугаар зүйлийн 7.2 дах заалт, Засгийн газрын тогтоолын 1.6 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2014-2015 онд эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр тусламж үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын жагсаалтыг баталсан Эрүүл мэндийн сайдын 2014 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 174 дүгээр тушаалын хавсралтын дөрөвдүгээрийн Улаанбаатар хотын хэсэгт байгууллагын нэр МонМэс, байгууллагын төрөл эмнэлэг, тусламж үйлчилгээний төрөл мэс засал, шалгуур үзүүлэлт хангасан өвөрмөц 18, шийдвэр тэнцсэн гэж нэмэлт оруулсугай.

2. Нийслэлийн хүн амд мэс заслын тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын үйлчлэх хүрээг шинэчлэн баталсан эрүүл мэндийн сайдын 2014 оны 06 дугаар сарын 19-ний 209 дүгээр тушаалын хавсралтын Хан-Уул дүүрэг гэсэн хэсэгт МонМэс эмнэлэг гэж оруулсугай.

3. Тушаалуудад орсон өөрчлөлтүүдийг уг тушаалууд гарсан өдрөөс эхлэн мөрдүүлж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Ганчимэг/-д даалгасугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080557